



МОНГОЛ ДААТГАЛ

ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН МАТЕРИАЛ

2023

2023.04.29 | 14:00 ЦАГТ

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН
ТӨВ БАЙРАНД 3-Н ДАВХАР ХУРЛЫН ТАНХИМ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

АГУУЛГА

- Хурлаар хэлэлцэх асуудал
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудас
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалт
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар
- Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт болон хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой төсөл материалууд:
 - Монгол даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 23/07 тоот тогтоол
 - Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 23/06 тоот тогтоол, түүний тайлбар үндэслэл
 - Монгол даатгал ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт
 - Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийн санал
 - Монгол даатгал ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төслүүд

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ТАНИЛЦУУЛАХ БОЛОН ХЭЛЭЛЦҮҮЛЖ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛУУДЫН ЖАГСААЛТ

Танилцуулах асуудлууд:

- Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
- Компанийн 2022 оны санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитын дүгнэлт

Хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх асуудлуудын жагсаалт:

- Компанийн 2022 оны санхүү, үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
- 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

**“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

№	Хурлын дэг	Хугацаа /минут/
1	Хурлын ирцийг бүртгэх (саналын хуудсыг тоолох замаар)	10 минут
2	Хурлын ирцийг мэдээлэх, тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулах	3 минут
3	Хурлын дарга хурлыг нээж, дэгийг танилцуулах	5 минут
4	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар танилцуулах болон хэлэлцэж, шийдвэрлэх асуудлуудыг дараалалын дагуу танилцуулан асуулт хариулт явуулах, санал сонсох, саналын хуудсыг хурааж авах	50 минут
5	Хурлын завсарлага, хувьцаа эзэмшигчид, хурлын оролцогчдод цай, кофегоор үйлчлэх	10 минут
6	Тооллогын комиссын дүн болон тогтоолыг уншиж танилцуулах	5 минут
7	Хурлаас гарах хувьцаа эзэмшигчдийн шийдвэр тогтоолыг уншиж танилцуулах	5 минут
8	Хурлын дарга хурлыг хаах	2 минут
	Нийт хугацаа	90 минут

“Монгол Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол Даатгал” ХК-ийн байранд, 3 давхрын хурлын танхимд хуралдана.

1. Хувьцаа эзэмшигчийн овог нэр:
2. Регистрийн дугаар:
3. Санал өгөх хувьцааны тоо:
4. Хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны дансны дугаар:
5. Үйлчилсэн ҮЦК-ийн нэр:
6. Үйлчилсэн ҮЦК-ийн ажилтны овог, нэр:

Хурал зохион байгуулах комисс

Хурлаас гаргах шийдвэр	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1. Монгол Даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах	
2. 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах	

Хувьцаа эзэмшигч /гарын үсэг/
Тооллогын комиссын дарга/гарын үсэг/
Гишүүд/гарын үсэг/

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Засварласан, балласан, залруулгатай санал авах хуудсыг нь хүчингүйд тооцогдоно.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо санал өгөх кумулятив аргыг ашиглана. Энэ аргаар саналаа өгөхдөө эзэмшиж буй хувьцааныхаа тоог 6-аар үржүүлж гарсан тоог ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнд дурын харьцаагаар хувааж өгнө. Харин хувьцааныхаа тоог 3-аар үржүүлж гарсан саналын тоог хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 3 хүнд дурын харьцаагаар хувааж саналаа өгнө. Тухайлбал, таны эзэмшиж буй хувьцааны тоо 100 гэвэл 600 саналыг ердийн гишүүнд нэр дэвшиж буй 6 хүнээс нэг хүнд бүгдийг нь өгч болно, эсвэл нэгэнд нь 500 саналаа 2 дахад нь 100 саналаа гэх мэтээр ямар ч харьцаагаар хувааж өгч болно. 300 саналаа хараат бус гишүүнд нэр дэвшиж буй нэг хүнд бүгдийг нь эсвэл 3 хүнд адилхан 100 санал өгөх мэтээр хувааж өгч болно. Гэхдээ хараат бус гишүүнд нийт саналынхаа 1/3-ыг ердийн гишүүнд нийт саналынхаа 2/3-ыг өгсөн байх ёстой. Ингээгүй бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигч өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө. Энэ тохиолдолд саналын хуудсыг хүлээн авсан брокер гарын үсэг зурж, тэмдэг дарсан байна.
4. Хэрэв саналаа өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүний овог нэр, хаягийг дор бичих бөгөөд өөрийн санал авах хуудас, иргэний үнэмлэх, хувьцаа эзэмшиж буй баталгаа болгон үнэт цаасны хадгаламжийн дансны хуулгыг хамт өгч явуулна.

Таны төлөөлөх хүний овог: нэр:.....

Оршин суугаа хаяг:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаар 94001934 утсаар лавлаж болно.

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан:

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХТАЙ ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Монгол даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн 23/07 тоот тогтоол
2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 23/06 тоот тогтоол, түүний тайлбар үндэслэл
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийн санал
4. Монгол даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
5. Монгол даатгал ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Компанийн нэр: “Монгол даатгал” ХК

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 14.00 цагт
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол
даатгал” ХК-ийн байранд 3 давхарт хурлын танхим

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн
жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

- “Монгол даатгал” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт
бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:


- Хувьцаа эзэмшигчид 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр
сарын 28-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандах
компанийн цахим хуудсаар www.mongoldaatgal.mn эсвэл компанийн байранд
ирж, хурал зохион байгуулах комиссын дарга Т.Цацралд мэдэгдэн хурлын баримт
бичигтэй танилцаж болно.
- Саналын хуудсаа бөглөж ирүүлэх зааврыг цахим хуудаст www.mongoldaatgal.mn
тавигдсан мэдээллээс авна уу.
- Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гарагт 09.00 -17.00 цагийн
хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын даргын мэдээлэл:

Овог нэр: Түдэвийн Цацрал

Цахим шуудангийн хаяг: Tsatsral.T@mongoldaatgal.mn

Утас: 9400-1934



МОНГОЛ ДААТГАЛ


**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**


20 **23** оны **03** сарын **21** өдөрДугаар **23107**Улаанбаатар хот


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл болон 62 дугаар зүйлийн 62.1 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2. дахь заалт, “Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам, Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- “Монгол Даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол Даатгал” ХК-ийн байранд 3 давхарт хурлын танхимд хуралдуулсугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - Монгол Даатгал ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2023 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын зардлын төсвийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
- Хурлын тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д хүргүүлэх өдрийг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2023 оны 03 дугаар сарын 23, 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрүүд байхаар тогтоосугай.
- Энэ тогтоолын 4-т заасан эхний өдөр буюу 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах, 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниудад хүргүүлэх, 2023 оны 03 дугаар сарын 23-ны болон 04 дүгээр сарын 06-ны өдрүүдэд



Бүүжин даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990

www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

өдөр тутам гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевиз, компанийн вэбсайт, сошиал хуудсаар мэдээлэх зэргээр хурлын мэдэгдэл, зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.

6. Дараах бичиг баримтыг хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг үнэт цаасны компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай.
 - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн хуулбар;
 - 6.2. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тэдгээрийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
 - 6.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн талаарх танилцуулга;
 - 6.4. Хурлын санал хураах хуудас;
 - 6.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийн төсөл;
 - 6.6. Хурлын зар.
7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №01-ээр, хурлын дэгийг Хавсралт №02-оор, танилцах бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №03-аар, хурлын зарыг Хавсралт №04-өөр тус тус баталсугай.
8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 14:00 цагаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалахыг ТУЗ-ийн гишүүн Б.Аюушд даалгасугай.
10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй сонгосугай. Үүнд:
Дарга: Ч. Бат-Өлзий
Гишүүд: М. Амар
11. Хурал зохион байгуулах комиссын даргаар Т.Цацралыг томилсугай.
12. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, төсөл, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хууль тогтоомжинд нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Т.Цацрал/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.

МОНГОЛ ДААТГАЛ
МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

20 23 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 23/06

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 46-р зүйлийн 46.1, 46.5, 46.6 дахь заалт, "Даатгалын тухай хууль"-ийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, "Компанийн дүрэм"-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, эрсдэлийн түвшинг харгалзан 2022 оны ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоолыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д, 2023 оны 4 дүгээр сард хуралдах хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан, шалтгаан, үндэслэлийг тайлбайрлахыг Гүйцэтгэх захирал /О.Эрдэнэбулган/-д тус тус үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



ГРОМОВ С.Б.





“ФИСКАЛ АУДИТ” ХХК

Монгол улс, Улаанбаатар-14241

Сүхбаатар дүүрэг 7-р хороо, 11-р хороолол, Эрхүүгийн
гудамж, Ориент төв 208 тоот

Утас/факс: (976)- 70106099, 99192177, 99991914

E-mail: audit@fiscal.mn, altantugs@fiscal.mn

2023.03.16 № А 19/23

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгдсэн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх аудитын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компаний удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох

“Монгол Даатгал” ХК

Хараат бус аудиторын дүгнэлт

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

бүртгэлийн зохих бодлогыг сонгож хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.


Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага


Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилсан сонгодог бөгөөд үүнд залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компаний санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцоолууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдалд байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компаний тухай хууль”-ийн 5-р зүйлд заасан хуулийн этгээд болох “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн удирдлагад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.






“Монгол Даатгал” ХК
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан
(Мян.төг)

ХӨРӨНГӨ	2021/12/31	2022/12/31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,482,587.5	2,229,129.0
Дансны авлага	966,406.7	2,365,557.7
Татвар, НДШ-ийн авлага	42,317.2	33,074.9
Бусад авлага	8,734,730.8	7,061,092.9
Бусад санхүүгийн хөрөнгө	5,872,130.5	7,210,277.8
Бараа материал	477,684.7	408,730.2
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	561,201.0	780,007.8
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	19,137,058.4	20,087,870.3
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	8,594,654.6	8,608,750.0
Биет бус хөрөнгө	3,821.5	1,364,971.5
Биологийн хөрөнгө	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	7,951,283.9	7,421,335.2
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,360,052.5	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	17,909,812.5	17,395,056.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	37,046,870.9	37,482,927.0

"ФИСКАЛ АУДИТ" ХХК

Захирал  Д.Алтантөгс


Аудитор  Н.Мягмарцэрэн
Аудитор Н.Болорцэцэг
Аудитор /гэрээт/  А.Мөнхжаргал






“Монгол даатгал” ХК
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан санхүүгийн байдлын тайлан
(Мян.төг)

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2021/12/31	2022/12/31
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	488,376.1	3,345,037.9
Цалингийн өглөг	13,564.6	13,260.8
Татварын өглөг	193,214.8	404,884.1
НДШ-ийн өр	115.1	113.3
Банкны богино хугацаат зээлийн өглөг	-	-
Хүүний өглөг	-	-
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	495,593.8	514,380.4
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	675,585.9	503,065.0
Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,866,450.3	4,780,741.5
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	-	-
Нөөц /өр төлбөр/	21,101,928.7	18,457,623.3
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,101,928.7	18,457,623.3
Нийт өр төлбөрийн дүн	22,968,379.0	23,238,364.8
Эзэмшигчийн өмч		
Эзний өмч /хувийн/	6,413,234.1	6,413,234.1
Халаасны хувьцаа	(9,857.1)	(9,857.1)
Нэмж төлөгдсөн капитал	4,522.6	4,522.6
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	7,038,875.8	7,038,875.8
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг / алдагдал /	631,716.5	797,786.8
Эзэмшигчийн өмчийн нийт дүн	14,078,491.9	14,244,562.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	37,046,870.9	37,482,927.0

"ФИСКАЛ АУДИТ" ХХК

Захирал  Д.Алтантөгс


Аудитор  Н.Мягмарцэрэн
Аудитор Н.Болорцэцэг
Аудитор /гэрээт/  А.Мөнхжаргал



“Монгол Даатгал” ХК
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан дэлгэрэнгүй орлогын тайлан

	2021/12/31	2022/12/31
Борлуулалтын орлого (цэвэр)	29,223,393.8	27,195,805.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	22,016,782.3	15,654,472.1
Нийт ашиг/алдагдал	7,206,611.5	11,541,333.5
Түрээсийн орлого	98,330.7	125,320.2
Хүүний орлого	845,397.2	13,499.5
Ногдол ашгийн орлого	206,072.4	-
Эрхийн шимтгэлийн орлого	495,317.7	507,099.6
Бусад орлого	192,243.5	397,178.6
Борлуулалт, маркетингийн зардал	7,103,266.3	8,016,726.6
Ерөнхий ба удирдлагын зардал	3,313,925.0	3,708,933.8
Санхүүгийн зардал	-	16,887.2
Бусад зардал	362,026.1	570,820.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	65,860.5	55,963.1
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	5,161.0	7,781.8
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	1,980,558.7	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	316,335.8	334,808.0
Орлогын татварын зардал	202,346.2	168,737.7
Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	113,989.6	166,070.3
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	113,989.6	166,070.3
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	113,989.6	166,070.3
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-


“ФИСКАЛ АУДИТ” ХХК
Захирал *Д.Алтантөгс* Д.Алтантөгс
Аудитор *Н.Мягмарцэрэн* Н.Мягмарцэрэн
Аудитор *Н.Болорцэцэг* Н.Болорцэцэг
Аудитор /гэрээт/ *А.Мөнхжаргал* А.Мөнхжаргал



“Монгол Даатгал” ХК
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан

Агуулага	Хувьцаат капитал	Хялвасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/алдагдал	(Мян.төг) Дүн
2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	6,413,234.1	(10,932.8)	4,522.6	7,038,875.8	-	517,250.3	13,962,950.0
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	476.6	476.6
Залруулсан үлдэгдэл	6,413,234.1	(10,932.8)	4,522.6	7,038,875.8	-	517,226.9	13,963,426.6
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	113,989.6	113,989.6
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	1,075.7	-	-	-	-	1,075.7
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,413,234.1	(9,857.1)	4,522.6	7,038,875.8	-	631,716.5	14,078,491.9
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	6,413,234.1	(9,857.1)	4,522.6	7,038,875.8	-	631,716.5	14,078,491.9
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	166,070.3	166,070.3
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,413,234.1	(9,857.1)	4,522.6	7,038,875.8	-	797,786.8	14,244,562.2



“ФИСКАЛ АУДИТ” ХХК
Захирал *Д.Алтантөгс* Д.Алтантөгс
Аудитор *Н.Мягмарцэрэн* Н.Мягмарцэрэн
Аудитор *Н.Болорцэцэг* Н.Болорцэцэг
Аудитор /гэрээт/ *А.Мөнхжаргал* А.Мөнхжаргал



“Монгол Даатгал” ХК
2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх
Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан

	(Мян.төг)	
	<u>2021/12/31</u>	<u>2022/12/31</u>
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(799,474.60)	267,823.20
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн	702,603.50	(459,481.70)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(61,800.00)	(61,800.00)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(158,671.10)	(253,458.50)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,641,258.60	2,482,587.50
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,482,587.50	2,229,129.00

“ФИСКАЛ АУДИТ” ХХК
Захирал  Д.Алтантөгс


Аудитор  Н.Мягмарцэрэн
Аудитор  Н.Болорцэцэг
Аудитор /гэрээт/  А.Мөнхжаргал

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ


2022 оны компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн хураангуй, санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлт дээр үндэслэн “МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ийн ТУЗ-ийн зүгээс дараах дүгнэлтийг гаргасныг танилцуулж байна.

1. Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүдийн талаар

Нийт даатгалын салбарын зах зээлийн талаар, компанийн өрсөлдөх чадвар, нийгэмд бий болгосон баялаг, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар зэрэг үзүүлэлтийг танилцуулъя.



Салбарын болон компанийн өсөлт



	2021 он	2022 он
Нийт хөрөнгө	37,046,870,911	37,482,927,077
Нийт хураамж	29,223,393,836	27,195,805,569
Даатгуулагчийн тоо	194,572	168,180
Нөхөн төлбөр	8,778,213,456	7,495,068,520
Системд эзлэх хувь	13%	8.1%
НТ авсан даатгуулагчийн тоо	9,519	9,114
Нийт ажиллагсдын тоо	216	210
Бүтээмж	135,293,489	129,503,836

Он	ROE	ROA	ROI	Хохирлын харьцаа	Зардлын харьцаа	Хос харьцаа
2021	0.80%	0.30%	37.70%	56%	69%	125%
2022	1.20%	0.44%	5%	47%	77%	124%

2. Санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар

Санхүүгийн тайлангийн талаар зохих хууль тогтоомжуудын дагуу Хувьцаат компаниуд нь хөндлөнгийн аудитын дүгнэлт хийлгэх ёстой байдаг ба ТУЗ-өөс “Фискал аудит” аудитын компанийг сонгож дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Компанийн хувьд 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартад нийцүүлэн Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалын дагуу гарган зохих тайлбар тодруулгын хамт Сангийн яам, татварын байгууллага болон санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн байна.

2022 онд ердийн даатгалын салбар нийт хураамж 23%, цэвэр хураамжийн дүн 25.2%-иар өссөн нь даатгалын салбарын өсөлтийн хурдтай байгааг илтгэж байна. “Монгол Даатгал” ХК-ийн хувьд нийт хураамжийн орлого өмнөх оноос 7%-иар буурсан, 27.2 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого, 14.56 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн

орлого төвлөрүүлж, үүнээс 7.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгож, нийт 166 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компанийн орлогын төлөвлөгөө биелэлт нийт хураамжаар 82%, цэвэр хураамжийн төлөвлөгөө биелэлт 76%-тай ажилсан байна. Компанийн хувьцаа нь хөрөнгийн биржийн “II” самбарт байршдаг. Хувьцааны үнэ (2022-02-04-ны өдрийн байдлаар) 3050 төгрөгийн ханштай, компанийн зах зээлийн үнэлгээ 195,603,640,050.00 төгрөг байгаа бөгөөд цаашид хувьцааны үнэ буурах хандлагатай гэж үзэж байна.

Цаашид МУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, чиглэл арга хэмжээнүүдтэй уялдсан оновчтой, уян хатан стратеги, менежментийн бодлого баримтлан компанийн өрсөлдөх чадварыг сайжруулан салбарын өсөлтөөс хувь хүртэж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, дансны авлагыг бууруулах, хөрөнгийн зохистой харьцааг хангаж ажиллах нь зүйтэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ


МОНГОЛ ДААТГАЛ
МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 23/01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.9 дэх заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.1 дэх заалт, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.
2. 2023 онд Компанийн ашгийг нэмэгдүүлж, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АЮУШ



Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990

www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn


МОНГОЛ ДААТГАЛ
МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 23/02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн 62.1.13 дахь заалт, "Монгол Даатгал" ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн 7.8.5 дахь заалт, 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. "Монгол даатгал" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны зардлын төсвийг хавсралт №01-ээр баталсугай.
2. Батлагдсан төсвийг мөрдөн, ТУЗ-ийн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг ТУЗ-ийн дарга /Громов С.Б./-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Б.АЮУШ



Буухиа даатгал: +976 7010-1990
Даатгалын лавлах: +976 1800-1990

www.mongoldaatgal.mn
insurance@mongoldaatgal.mn

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсвийн санал

№	Ангилал	Нийт төсөв
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин	26,400,000
2	ТУЗ-ийн дэргэдэх хороодын хурлын цалин	3,200,000
3	Эчнээ санал хураалтын цалин	4,800,000
4	Хурлын бусад зардал	1,500,000
	Нийт дүн	35,900,000



Эцэг /эх/-ийн нэр:

Громов

Өөрийн нэр:

СЕРГЕЙ БОРИСОВИЧ

Төрсөн он: **1968 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0930167

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДАРГА

БОЛОВСРОЛ:

- 1985-1992 онд Сибирийн өнгөт металын судалгааны хүрээлэнгийн их сургууль, Инженер

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1994 - 2000 онд Транс Уорлд Алюминиум компани, Нөөцийн газрын захирал
- 2001- 2016 онд Чингис хаан банк, ТУЗ-ийн дарга
- 2004 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн дарга



Эцэг /эх/-ийн нэр:
Очиржанцан

Өөрийн нэр:
ЦОГТ

Төрсөн он: **1969 он**

Гадаад хэлний мэдлэг:
Англи, Орос, Япон

Компанийн засаглалын
гэрчилгээний дугаар:
0430751

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1977 - 1987 онд Архангай, Цэцэрлэг хотын 10н жилийн сургууль
- 1987 - 1993 онд ЗХУ, Ленинградын Инженер Эдийн засгийн дээд сургууль, Инженер эдийн засагч
- 1996 - 1998 онд Япон, Иокогамагийн их сургууль, Татвар ба санхүү

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1994 - 2009 онд Татварын ерөнхий газар, Багш, Байцаагч, Хэлтсийн дарга
- 2009 - 2011 онд Хүлэг ХХК, Захирал
- 2011 - одоог хүртэл Хүлэг консалтинг ТМЗ ХХК, Татварын зөвлөх

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ:

- 6 сар Япон, Азийн эдийн засгийн судалгааны төв Гадаад худалдаа, хөрөнгө оруулалт
- 14 хоног АНУ, Дотоод орлогын газар Санхүүгийн үүсгэмэл бүтээгдэхүүн
- 14 хоног Австрали, Гриффит их сургууль Уул уурхай ба татвар
- 14 хоног Канад, Ванкувэр их сургууль Ашигт малтмалын арилжаа
- 14 хоног Солонгос, OECD Center Хил дамнасан арилжаа
- 14 хоног БНХАУ, Шанхай, Фуданы их сургууль Хөрөнгө оруулалт



Эцэг /эх/-ийн нэр: **Базар**

Өөрийн нэр: **АЮУШ**

Төрсөн он: **1953 он**

Гадаад хэлний мэдлэг:
Англи, Орос

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1961 - 1971 онд Нийслэлийн 24 дүгээр дунд сургууль
- 1971 - 1974 онд Монгол улсын их сургууль, Эдийн засаг бакалавр
- 1988 - 1992 онд Плехановын нэрэмжит Оросын эдийн засгийн академи, Эдийн засаг магистр
- 2009 - 2011 онд Түшээ дээд сургууль, Эдийн засаг магистр

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1974 - 1977 онд ТТХЕГ, Орлогч ня-бо
- 1977 - 1995 онд Монгол улсын их сургууль, Багш
- 1995 - 2006 онд Үнэт цаасны хороо, Хэлтсийн дарга
- 2006 - 2010 онд Санхүүгийн зохицуулах хороо, Газрын орлогч дарга
- 2010 - 2013 онд Санхүүгийн зохицуулах хороо, Даргын орон тооны бус зөвлөх
- 2013 - одоог хүртэл Мандах дээд сургууль, Зөвлөх профессор
- 2017 - 2019 онд ДиБиЭм ассет менежмент, Ахлах аудитор
- 2019 - одоог хүртэл Райнос ассет менежмент, Ахлах аудитор



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ АНКЕТ

Эцэг /эх/-ийн нэр:
Бавуудорж

Өөрийн нэр:
ЭНХТУЯА

Төрсөн он: **1962 он**

Гадаад хэлний мэдлэг:
Англи, Орос

БОЛОВСРОЛ:

- 1969 - 1979 онд Нийслэлийн 18 дугаар сургууль
- 1979 - 1984 онд МУИС-Политехникийн дээд сургууль, Аж үйлдвэрийн эдийн засаг зохион байгуулалт, Инженер-эдийн засагч
- 1995 - 1997 онд ШУТИС-КТМС, Бизнесийн удирдлагын магистр
- 1999 - 2003 онд Удирдлагын академи, Удирдахуйн ухааны доктор

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 1984 - 1995 онд Улаанбаатарын Махкомбинат, Эдийн засагч
- 1995 - 1996 онд ОНУХ сан, Төслийн ажилтан
- 1996 - 2006 онд ШУТИС-КТМС, Багш, Ахлах багш, Дэд профессор
- 2006 - 2014 онд ШУТИС-КТМС, Тэргүүлэх профессор, ЭЗМС-ийн эрхлэгч
- 2014 - одоог хүртэл ШУТИС-БУХС, Профессор, Салбарын эрхлэгч



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

Эцэг/эх/-ийн нэр: **Сүхээ**

Өөрийн нэр: **ТЭНГИС**

Төрсөн он: **1983**

Гадаад хэлний мэдлэг:

Англи

Компанийн засаглалын
гэрчилгээний дугаар:
0930370

БОЛОВСРОЛ:


- 2000 - 2002 онд ШУТИС-Лицей сургууль Бүрэн дунд боловсрол
- 2002 - 2006 онд ШУТИС-Компьютерийн Техник Менежментийн Сургууль Программ хангамжийн инженер

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2005 - 2006 онд Интерактив ХХК Программ хангамжийн инженер
- 2006 - 2014 онд Мобиком Корпораци ХХК Программ хангамж, Мэдээллийн аюулгүй байдал, Орлогын урсгалын байцаагч
- 2014 - 2018 онд Супреим Сольюшн ХХК Гүйцэтгэх захирал

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ:

- 2019 - 2019 онд Засгийн газар, Оксфордын их сургууль Төслийн менежер
- 2020 - 2021 онд Цахим хөгжлийн үндэсний хороо Ажлын албаны дарга



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

Эцэг /эх/-ийн нэр:

Огай

Өөрийн нэр:

НАТАЛЬЯ ЮРЬЕВНА

Төрсөн он: **1976 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0130813

БОЛОВСРОЛ:

- 1993 - 1998 онд Эрхүү хотын гадаад хэлний дээд сургууль, Хэл зүйч
- 2006 - 2009 онд Плехановын нэрэмжит Эдийн засгийн академи, Санхүүч

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2003 - 2005 онд Сибэкология, Худалдааны хэлтсийн дарга
- 2005 - 2016 онд Чингис хаан банк, Тусгай төслийн газар
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал ХК, ТУЗ-ийн ажлын алба



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

Эцэг/эх/-ийн нэр: **Лизунова**

Өөрийн нэр: **ТАНЯ**

Төрсөн он: **1983**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

00279

БОЛОВСРОЛ:

- 1990 - 2000 онд ОХУ, ЭСЯ-ны дэргэдэх дунд сургууль Бүрэн дунд
- 2000 - 2004 онд МУИС Эдийн Засгийн Сургууль Банк санхүү бакалавр

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2006 - 2016 онд “Чингис Хаан” банк ТУЗ-ийн даргын туслах
- 2006 - 2014 онд Мобиком Корпораци ХХК Программ хангамж, Мэдээллийн аюулгүй байдал, Орлогын урсгалын байцаагч
- 2016 - одоог хүртэл Монгол Даатгал” ХК ТУЗ-ийн ажлын алба



Эцэг /эх/-ийн нэр:

Громов

Өөрийн нэр:

БОРИС СЕРГЕЕВИЧ

Төрсөн он: **1991 он**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0930369

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 2012 - 2015 онд Раффлс их сургууль, Сингапур
- 2017 онд CFA Institute Санхүүгийн шинжээч

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2013 - 2013 онд АПУ ХК Маркетингийн дадлагажигч
- 2012 - 2013 онд “Чингис Хаан” банк Интернет банк хөгжүүлэгч
- 2014 - 2014 онд “Блю Скай Кашемир” ХХК Гадаад худалдааны менежер
- 2016 - 2017 онд KPMG Audit ХХК Мэргэжилтэн
- 2017 - Одоог хүртэл Аya enterprises ХХК Захирал



Эцэг/эх/-ийн нэр:

Очирбат

Өөрийн нэр:

ЭРДЭНЭБУЛГАН

Төрсөн он: **1979**

Гадаад хэлний мэдлэг:

Англи, Орос

Компанийн засаглалын

гэрчилгээний дугаар:

0430755

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ

БОЛОВСРОЛ:

- 1986 - 1996 онд Эрдэнэт хотын 4-р 10 жилийн сургууль
- 1996 - 2001 онд КТМС, ШУТИС Санхүүгийн менежмент бакалавр
- 2004 - 2008 онд КТМС, ШУТИС Санхүүгийн менежмент магистр
- 2015 - 2017 онд “Гүрэн” дээд сургууль Төрийн захиргааны менежмент

АЖЛЫН ТУРШЛАГА:

- 2003 - 2008 онд “Service for Peace” NGO Гүйцэтгэх захирал
- 2008 - 2009 онд “Хатан Зо” ХХК Гүйцэтгэх захирал
- 2010 - 2014 онд “Педерсен энд Партнерс” ХХК Захирал
- 2013 - 2018 онд “Роял Өүшн” ХХК Гүйцэтгэх захирал
- 2019 - 2020 онд “Монгол Даатгал” ХК Үйл ажиллагаа хариуцсан газрын захирал
- 2020 - одоог хүртэл “Монгол Даатгал” ХК Гүйцэтгэх захирал

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ:

- 7 хоног Дэйл Карнеги Трэйнинг Амжилтын үндэс
- 2 сар Колумбын Их Сургууль Хувь хүний манлайлал
- 6 сар Харвард Бизнес Пабблишин ManageMentor

ТЭМДЭГЛЭЛ

The page is designed for handwritten notes. It features a central gap where a large, light-colored watermark of the Mongolian national emblem is placed. The rest of the page is filled with horizontal lines for writing. At the top, there are two header sections with the text 'ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ 2023' (Shareholders' Meeting 2023). Below the header on the left is the section title 'ТЭМДЭГЛЭЛ' (Summary).



МОНГОЛ ДААТГАЛ